

UCS 1107B:2025

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Ерөнхий боловсролын сургуулийн
барилгын дотор засалд тавих шаардлага

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын
дотор засалд тавигдах шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/07-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт	5
4. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	6
5. Материалд тавигдах ерөнхий шаардлага.....	7
6. Хана, тааз	8
7. Хаалга	9
8. Цонх.....	9
9. Шал.....	10
10. Шат	11
11. Гэрэлтүүлэг	12
12. Цахилгааны тоноглол.....	14
13. Халаалт агааржуулалт.....	14
14. Анги танхим, өрөө тасалгааны хаяг, тэмдэглэгээ	15
15. Ариун цэврийн өрөө	16
16. Хонгил (коридор)	20
17. Аюулгүй байдалд тавих шаардлага	21
18. Шалгах хуудас	21
Ашигласан материалын жагсаалт	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сургуулийн барилгын дотор функц	6
Зураг 2. Хоёр давхар гипсэн хавтангийн хэсэглэл	8
Зураг 3. Цахилгааны гаргалгаа /разетка/, гэрлийн унтраалгын өндөр.....	8
Зураг 4. Брайл тэмдэглэгээг шатны бариул дээр суурилуулах.....	11
Зураг 5. Гэрлийн өнгөний температур (Kelvin).....	13
Зураг 6. Гэрлийн тусгал (IES).....	13
Зураг 7. Хичээлийн танхимын хаяг, дугаар	15
Зураг 8. Өрөө тасалгааны хаяг, дугаарын самбар.....	15
Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тэмдэг.....	16
Зураг 10. Танхимын хүчин чадлын тэмдэглэгээ	16
Зураг 11. Ариун цэврийн өрөөний кабины хэмжээ /Дотогшоо онгойлттой/	17
Зураг 12. Ариун цэврийн өрөөний кабины хэмжээ /Гадагшаа онгойлттой/	17
Зураг 13. Бие засах кабины нүүр тал	18
Зураг 14. Бие засах кабины хажуу тал.....	18
Зураг 15. Сурагчдын насны ангилалд зориулсан хөтөвчний хэмжээ (писсуар).....	18
Зураг 16. Тулгуур таяг ашигладаг ХБИргэнд зориулсан хөтөвч	18

Зураг 17. Тулгуур таяг ашигладаг ХБИргэнд зориулсан хөтөвч	18
Зураг 18. Ариун цэврийн өрөөний таних тэмдэг.....	19
Зураг 19. Тосгуурын хэмжээ.....	19
Зураг 20. ХБИргэнд зориулсан ариун цэврийн өрөө.....	20
Зураг 21. ХБИргэнд зориулсан ариун цэврийн өрөө.....	20
Зураг 22. Сургуулийн хонгил /Коридор/.....	20
Зураг 23. Гарц тэмдэг	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шалны материал.....	10
Хүснэгт 2. Анги танхимын агаар сэлгэлтийн хугацаа	14
Хүснэгт 3. Ариун цэврийн өрөөний норм	16
Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт	21



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 45/07

Улаанбаатар хот

Нийгмийн дэд бүтцэд хамаарах
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Нийгмийн дэд бүтэц” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1106B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1107B:2025 “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1108B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;

1.4. UCS1109B:2025 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1101C:2025 “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17 10 33

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/07
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

UCS 1107B:2025

“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ДОТОР ЗАСАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор заслыг төлөвлөх, гүйцэтгэх, хүлээн авахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага;
- MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;
- MNS 6767:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага;
- БНБД 31-25-22 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт;
- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга;
- ТН-11-2.2-1985 Ерөнхий боловсролын сургууль. дотуур байрын барилгын төлөвлөлтийн элементийн норм;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- БД 31-113-11 Ерөнхий боловсролын сургуулийн барилга төлөвлөлт;
- БНБД 11-66-88 Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм;
- БНБД 11-01-98 Зураг, төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм;
- БНБД 13-04-03 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар эдэлгээний хугацааны жишиг норм.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий боловсролын сургууль – боловсролын үйл ажиллагааг гол зорилгоо болгож бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй боловсролын байгууллагыг;


Сургалтын танхим – гэж төрөл бүрийн хичээл явуулахад зориулсан танхимыг;

Лаборатори – гэж багш, туслах ажилтан тоног төхөөрөмжөө хадгалах, туршилт хийх өрөөг;

Рекреаци – амрах хэсэг.

4. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Сургуулийн барилгын зохион байгуулалтыг ашиглалтын хувьд сурган хүмүүжүүлэх төрөл бүрийн бүтэц бүхий олон төрлийн зориулалттай байхаар төлөвлөнө.
- 4.2. Хүүхдийн насны онцлог болон биеийн хөдөлгөөнд тохирсон, тухтай, аюулгүй орчныг бүрдүүлэх эргономик төлөвлөлт хийнэ.



Зураг 1. Сургуулийн барилгын дотор функц (жишээ зураг)

- 4.3. 1-5 дугаар ангийн сурагчдад зориулсан хичээлийн анги, танхимыг 2-оос доош давхарт байрлуулна. Газар хөдлөлтийн 6 ба түүнээс доош баллын бүсэд барилгын гурваас дээш давхарт 10-12 дугаар ангийн сурагчдад зориулсан боловсрол, чөлөөт цагаа өнгөрөөх өрөө тасалгаа, захиргааны зориулалттай өрөө тасалгааг байрлуулна.
- 4.4. Сургуулийн барилгын дотор засалд дараах нийтлэг шаардлагыг хангуулна. Үүнд:
- сурах аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлсэн байх;
 - ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хийхэд хялбар байх;
 - хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан байх.

4.5. Сургуулийн барилгын үндсэн өрөө тасалгааны бүрдлийг БНБД 31-25-22-д заасан дараах шаардлагын дагуу төлөвлөнө. Үүнд:

- 1 дүгээр ангийн сурагчдад зориулсан унтлага, тоглоом (төсөлд өгөгдсөн даалгавраар амралтын өрөөтэй бол), ариун цэврийн өрөөтэй 3-аас цөөнгүй хичээлийн анги, танхим;
- 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан амрах хэсэг (рекреаци) үйлчилгээний ба ариун цэврийн өрөөтэй 6-гаас цөөнгүй хичээлийн анги танхим, мөн хөдөлмөрийн хичээлийн танхим, өдөр өнжүүлэх бүлэгт зориулсан тусгай өрөө;
- 6-12 дугаар ангийн сурагчдад зориулсан хичээлийн анги, танхимыг түр амрах хэсэг ба ариун цэврийн өрөөтэй холбож төлөвлөх (сурагчдад зориулсан өрөө тасалгааны бүлэгт багтааж эсвэл сургалтын хэсгийн гадна байршуулж болно);
- 5 дугаар ангийн сургалтын хэсэг тусдаа, бусад насны бүлгийн хүүхдүүд дундуур нь өнгөрөн гарах боломжгүй байдлаар төлөвлөх;
- Үндсэн хичээлийн анги танхимын бүрдэл, талбайн хэмжээг БНБД 31-03-03*/11 дагуу төлөвлөх;
- Ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг харгалзан анги танхим бүрд угаалтуур төлөвлөнө.

4.6. Ширээ, хана, багана, шат, толины ирмэг нь булангийн хамгаалалттай байна.

4.7. Сургуулийн дотор засалд хүүхдийн аюулгүй сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэн дараах иж бүрдлүүдийг барилгын онцлогтой уялдуулан гүйцэтгэнэ. Үүнд:

- Хана;
- Шал;
- Шат;
- Хаалга;
- Цонх;
- Гэрэлтүүлэг, цахилгааны тоноглол;
- Халаалт, агааржуулалт болон холбогдох тоноглол.

4.8. Барилгын дотор засал болон их засварын ажлыг сургалтын үйл ажиллагааг эхлэхээс 1 сарын өмнө бүрэн дуусгасан байхаар төлөвлөнө.

5. МАТЕРИАЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. Сургуулийн барилгын дотор засалд эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл болон тохирлын гэрчилгээтэй барилгын материал хэрэглэнэ.

5.2. Цахилгааны аюулгүй байдлыг хангасан, галд тэсвэртэй материалыг сонгон ашиглана.

5.3. Сургуулийн дотор засалд ашиглах барилгын материал нь удаан эдэлгээтэй, бат бөх, ус, дулаан, чийг тусгаарлах чадвартай, байгальд ээлтэй материал байна.

5.4. Дараах материалуудыг хэрэглэхийг хориглоно. Үүнд

- Хурц үнэртэй;
- Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, чийг шингээдэг;
- Хэрэглэхийг хязгаарласан химийн бодисын жагсаалтад багтсан найрлагатай.


5.5. Сургуулийн таазны материалыг сонгохдоо дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Галд тэсвэртэй материал ашиглах /гипс хавтан (gypsum board) болон минерал влак хавтан (mineral fiber board)/;
- Акустик чанартай, дуу чимээг шингээж тусгаарлах материалуудыг ашиглах /полистирол (polystyrene) хавтан/;
- Удаан хугацаанд тэсвэртэй, бат бөх материал ашиглах /PVC (polyvinyl chloride) болон металл таазны хавтангууд/;
- Ариун цэврийн өрөө болон ус чийг ихээр ялгарах өрөөнд ус чийгт тэсвэртэй таазны материалыг ашиглана.

6. ХАНА, ТААЗ


6.1. Дотор ханын материалд гадны нөлөөлөлд тэсвэртэй хөнгөн бетон блок, чулуун хавтан (плита) болон 2 давхар гипсэн хавтан байна.

Гипсэн ханын деталь



Зураг 2. Хоёр давхар гипсэн хавтангийн хэсэглэл (жишээ зураг)

- 6.2. Аюулгүй байдлыг харгалзан үзэж ариун цэврийн өрөөний тусгаарлах кабиныг металлаар хийж болно.
- 6.3. Анги танхим, түүнийг олон талт зориулалтаар ашиглах боломжийг хангахын тулд анги танхимд тусгаарлах хана, сургалтын болон амралтын өрөөний хооронд тусгаарлах хана ашиглахыг зөвшөөрнө.
- 6.4. Дотор ханын төвөгшилтэй хэлбэр хийцлэл төлөвлөхгүй байх нь зохистой.
- 6.5. Ханан дахь цахилгааны гаргалгаа /разетка/ шалнаас 400мм, гэрлийн унтраалгын 1500мм-ийн өндөрт байрлуулна.



Зураг 3. Цахилгааны гаргалгаа /разетка/, гэрлийн унтраалгын өндөр (жишээ зураг)

- 6.6. Сургуулийн барилгын өрөө тасалгаануудад цахилгаан болон холбооны утсыг ил гаргахгүй.
- 6.7. Хананы ерөнхий өнгө нь цагаан, бүдэг ногоон гэх мэт завсрын зөөлөн, цайвар өнгөнүүд байна.
- 6.8. Дүүжин таазнаас дээш барилгын хучилт хүртэлх дотор ханын заслыг өнгөлгөөний 2-р түвшнийг хангахаар гүйцэтгэнэ.
- 6.9. Хөдөлгөөний эрчим ихтэй газарт зэвэрдэггүй ган эсхүл тунгалаг нягт хуванцар булангуудаар ханын ирмэгийг хамгаална. Энэ нь хамгийн багадаа 2 мм зузаантай, хоёр талдаа 2.5-3см далавчтай, шалнаас дээш хамгийн багадаа 1.2 метр өндөртэй байна.

7. ХААЛГА

- 7.1. Хаалга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан байна.
- 7.2. Хаалга нь гэгээвчтэй байх бөгөөд шил нь цохилт, доргилтод тэсвэртэй хатаалгатай шил байна.
- 7.3. Хичээлийн анги танхимд орох хаалганы өргөн 0.9 м-ээс багагүй байна.
- 7.4. Коридор, гал тогоо, цайны газар, биеийн тамирын заал, узель, тоног төхөөрөмжийн өрөөний хаалгыг өргөн байхаар төлөвлөнө.
- 7.5. Хаалганы доод хэсэгт бат бөх, агаар сэлгэх зориулалтын решетокой (сараалж төмөр) байна.
- 7.6. Хичээлийн танхимын хаалга нь ангиас гадагш онгойлттой байна.
- 7.7. Хаалга нь хаагдахад шууд цоожлогдохгүй, хоёр тийш савж онгойдоггүй байна.
- 7.8. Хөдөлгөөнийг харгалзан үзэж хаалганд хязгаарлагчтай байна.
- 7.9. Ариун цэврийн өрөөний хаалга анги танхимын хаалганы өөдөөс харуулан эсрэг талд байрлуулахыг хориглоно.
- 7.10. Металл хаалгыг аюулгүйн гарц, биеийн тамирын заал, лаборатори, хувцас солих өрөөнд ашиглана.

8. ЦОНХ

- 8.1. Цонх нь “UCS 1501C Хаалга, цонхонд тавигдах ерөнхий шаардлага” стандартыг хангасан байх бөгөөд цонхны шил нь 3 давхар, LOW-E бүрэлттэй байх нь зохимжтой.
- 8.2. Цонхны үндсэн бүрдэл эд анги болох шилэн багц, нягтруулах жийрэг, түгжээний хэрэгсэл өнгөлгөөний материал, цавуунд ашиглалтын найдвартай ажиллагааны туршилт хийж баталгаажуулсан байна.
- 8.3. Цонхны өндөр 2.5м, өргөн нь 1.8м-2м-ээс багагүй байна.
- 8.4. Сургуулийн дотоод орчны агаарын чанарыг хамгаалахын тулд цонхны салхивчинд нарийн тоосонцор, утааны бохирдлыг шүүх, шавжаас хамгаалах нарийн шүүлтүүртэй байна.
- 8.5. Шүүлтүүр нь бат бөх, угсарч суурилуулах, засвар сайжруулалт, цэвэрлэгээ хийхэд хялбар байна.

9. ШАЛ


- 9.1. Дотор шал нь халтирдаггүй, бат бөх, удаан эдэлгээтэй, арчиж цэвэрлэхэд хялбар байна.
- 9.2. Ариун цэврийн өрөө, гал тогоо, цайны газар, үүдний хэсгийн шал халдваргүйжүүлэгч химийн бодисуудыг тэсвэрлэх чадвартай байна.
- 9.3. Сургуулийн орох, гарах гарц, шат, хонгил, анги танхимын шалыг халтирдаггүй материалаар завсаргүй хийж, хүрээг хана, шаланд бэхэлнэ.
- 9.4. Хулдаасан шалыг вакс түрхэж бэхжүүлнэ.
- 9.5. Шалны материалыг хүснэгт 1-д заасны дагуу сонгож хэрэглэнэ.

Хүснэгт 1. Шалны материал

Д/д	Тодорхойлолт	Материал	Тайлбар
1	Анги, танхим (I-VI анги)	Ламинат, Угсардаг хивсэнцэр (Carpet Tile), Паркет (Шахмал модон хавтан), Винил хавтан (Vinyl Plank)	-
2	Анги, танхим (VI-XII анги)	Ламинат, Угсардаг хивсэнцэр (Carpet Tile), Паркет (Шахмал модон хавтан), Винил хавтан (Vinyl Plank)	-
3	Коридор, хөлийн хэсэг	Резинэн хавтан, Сайн чанарын хулдаас (Vinyl Plank), Зориулалтын өнгөлсөн бетон	Металл үүдний гишгүүр хийхийг хориглоно.
4	Бага ангийн гимнастикийн заал	Зориулалтын резинэн шал	Спортын зориулалттай резинэн хольцтой материал хэрэглэнэ.
5	Дунд, ахлах ангийн гимнастикийн заал	Спортын зориулалттай модон шал	Спортын зориулалттай агч модон шал хэрэглэнэ.
6	Цайны газар	Резинэн шал, Өнгөлсөн бетон, Сайн чанарын хулдаас (Vinyl Plank)	Эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэрлэхэд хялбар материал байна.
7	Захиргаа, хүлээн авах хэсэг, оффис	Ламинат, Угсардаг хивсэнцэр (Carpet Tile)	-
8	Эмчийн өрөө	Сайн чанарын хулдаас (Vinyl Plank), Өнгөлсөн бетон	Эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэрлэхэд хялбар материал байна.
9	Гал тогоо	Сайн чанарын хулдаас (Vinyl Plank), Өнгөлсөн бетон	Халтирахаас сэргийлж арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд цэвэрлэхэд хялбар байна. Шалны хүрээгээр блинтүс байх шаардлагатай. Цагаан өнгийн материал зөвшөөрөхгүй.
10	Номын сан	Угсардаг хивсэнцэр (Carpet Tile)	-
11	Хөгжмийн өрөө	Угсардаг хивсэнцэр (Carpet Tile)	-
12	Шинжлэх ухааны хичээлийн танхимууд	Сайн чанарын хулдаас (Vinyl Plank), Өнгөлсөн бетон	-
13	Зургийн анги	Сайн чанарын хулдаас (Vinyl Plank), Өнгөлсөн бетон	-
14	Багш нарын өрөө	Ламинат, Угсардаг хивсэнцэр (Carpet Tile)	-
15	Ариун цэврийн өрөө	Чулуун хавтан (плита)	Керамик хавтан хэрэглэнэ.
16	Узел, техникийн өрөөнүүд	Өнгөлсөн бетон	-

10. ШАТ

- 10.1. Шатны бариул нь модон, резинэн бүрээстэй зэвэрдэггүй ган, хөнгөн цагаан, никель зэрэг материалаар хийгдсэн байхаас гадна хүүхдийн өндрийн хэмжээнд тохирсон байна.
- 10.2. Шат нь халтирдаггүй материалтай эсвэл халтирахаас сэргийлсэн хамгаалалттай байна.
- 10.3. Шатны ирмэгийн хамгаалалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- өндөр нь 4 мм-ээс ихгүй;
 - өргөн нь 5см–5.5см;
 - шалны өнгөнөөс тод ялгаралтай.
- 10.4. Хамгаалах хашлаганы материал нь гөлгөр гадаргуутай байх ба гагнуурын холбооснуудыг сайтар зүлгэж хурц ирмэг, шовх өнцөг гарахаас сэргийлсэн байна.
- 10.5. Шатны гишгүүр дээр цэцэг байрлуулах, зураг зурах гэх мэт хүүхдийн анхаарлыг сарниулж, аюулгүй зорчиход саад болох зүйлсийг хориглоно.
- 10.6. Харааны бэрхшээлтэй хүнд мэдээлэл авах зориулалттай брайл үсэг, хэвлэмэл үсгэн тэмдэглэгээг шатны өгсөх, уруудах бариул дээр суурилуулна.




Зураг 4. Брайл тэмдэглэгээг шатны бариул дээр суурилуулах (жишээ зураг)

- 10.7. Шат нь 1.2 м-ээс багагүй өндөр хашлагатай, хүүхдийн биеийн өндөрт тохирсон хоёр өөр түвшний бариултай байна.
- 10.8. Шатны гишгүүр болон эргэлтийн талбайг халтирдаггүй материалаар хийнэ.
- 10.9. Өгсөх, уруудах шатны хашлага хоорондын зайд хамгаалалт хийнэ.
- 10.10. Шатны орчинд халтирах, унахаас сэргийлэх таних тэмдэг, тэмдэглэгээг байршуулна.
- 10.11. Сургууль цахилгаан шат /лифт/-тай бол бүхээгийн гадна, дотор байрлах товчлуурууд болон аваарын хонх нь хүүхэд, тэргэнцэртэй иргэн хүрэх түвшинд хаалганы 2 талд байрлана.
- 10.12. Цахилгаан шат нь тэргэнцэртэй иргэн нэвтрэх боломжтой байна.
- 10.13. Цахилгаан шат нь байнгын гэрэлтүүлэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байна.
- 10.14. Цахилгаан шат нь гал түймэр гарсан үед барилгын 1 дүгээр давхарт автоматаар зогсож хаалга нь нээлттэй байхаар хийгдсэн байна.


11. ШАТ ГЭРЭЛТҮҮЛЭГ

- 11.1. Сургуулийн барилгад байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийг БНБД 23-02-08 “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг”-ийн дагуу төлөвлөнө.
- 11.2. Үндсэн анги танхим, өрөө тасалгааг нарны хэт халалтаас хамгаалах ба өрөөнд тусах нарны тусгалын тооцооллыг БНБД 23-04-07 “Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж”-ийн дагуу төлөвлөнө.
- 11.3. Гэрэлтүүлэг нь удирдлагын системтэй, гэрэлтүүлгийн хэмжээг тохируулах боломжтой байна.
- 11.4. Анги танхимд нарны шууд тусгал, гялбаанаас хамгаалж буулгадаг хөшиг хийнэ.
- 11.5. Гэрэлтүүлгийн хэрэгслийн суурь, бүрхүүлийг бат бөх тогтооно.
- 11.6. Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн дотор цахилгаан холболт болон гэрэлтүүлэг, хүчний тоноглолд урсгал засвар, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд тогтмол хийнэ.
- 11.7. Эрчим хүчний хэмнэлттэй байлгах үүднээс гэрэлтүүлэгт лед гэрэл ашиглана.
- 11.8. Гэрэлтүүлэг нь ердийн хичээлийн танхимд 300-500 люкс, уран зургийн хичээлийн өрөөнд 500-750 люкс байхаар гэрэлтүүлгийг хийнэ. Урлагийн танхимд 200 люкс, спорт танхим, усан сан, дуу хөгжмийн хичээлийн өрөө 300 люкс байна.
- 11.9. Хичээлийн танхимын гэрэлтүүлгийн өнгөний температур 3500 - 4000K байна.



Зураг 5. Гэрлийн өнгөний температур (Kelvin)

11.10. Гэрэлтүүлгийн тусгал нь жигд тархалттай гэрэлтүүлгийг сонгож хэрэглэнэ (Зураг 6).



Зураг 6. Гэрлийн тусгал (IES)

Тайлбар: Сургуулийн хичээлийн танхимд 4, 6, 7, 8, 9, 10, 12, 14, 15, 18, 19, 21, 25, 27, 29-р гэрлийн тусгалтай гэрлийг хэрэглэхгүй байх.

12. ЦАХИЛГААНЫ ТОНОГЛОЛ

- 12.1. Сургуулийн барилгын өрөө тасалгааны зохиомол гэрэлтүүлгийн эх үүсвэрт тавигдах шаардлагыг БНБД 23-02-08-ын дагуу төлөвлөнө.
- 12.2. Цахилгаан дамжуулах ил утсыг зориулалтын бүрхүүлээр далдална.
- 12.3. Сургуулийн хананд гэрэл, чимэглэл, цахилгаан төхөөрөмж байршуулах тохиолдолд 2 м-ээс дээш өндөрт байх бөгөөд цахилгааны утсыг далдална.
- 12.4. Гэрлийн унтраалга, цахилгаан тэжээлийн залгуурын бүрэн бүтэн, хэвийн ажиллагааг хангана.

13. ХАЛААЛТ, АГААРЖУУЛАЛТ

- 13.1. Сургуулийн барилга нь БНБД 31-03-03/*11, БНБД 41-01-11 болон холбогдох норм, стандартын шаардлагуудтай уялдуулан агаар сэлгэлтийн системээр тоноглогдсон байна. Үүнд:
 - анги танхим;
 - сургалтын кабинет (агаарын халаалтгүй байх);
 - лаборатори;
 - урлаг заал;
 - лекцийн танхим;
 - сургалтын менежер, багш нарын өрөө;
 - спортын танхим;
 - усанд сэлэлтийн өрөө;
 - хоолны газар;
 - эмнэлгийн төв;
 - кино камерын өрөө;
 - ариун цэврийн өрөө.
- 13.2. Анги танхим, өрөө тасалгааны харьцангуй чийгшилт 40-60 хувь байна.
- 13.3. Цонх бүр салхивчтай, саадгүй онгойлгох боломжтой, аюулгүйн хамгаалалттай байна.
- 13.4. Биеийн тамирын болон урлаг заал, хурлын заал, номын сангийн дулаан +15-аас 17°C, анги танхим, кабинет, лабораторийн өрөөний дулаан +17-аас 21°C байна.
- 13.5. Анги танхимын агаар сэлгэлтийг хүснэгт 2-т заасан давтамж, хугацаагаар тогтмол хийнэ.

Хүснэгт 2. Анги танхимын агаар сэлгэлтийн хугацаа


Гаднах хэм	Ангид салхи оруулах хугацаа /минут/	
	Хичээлийн завсарлага	Ээлж солигдох үед
+10-аас +6	4-өөс 10	25-аас 35
+5-аас 0	3-аас 7	20-оос 30
0-ээс (-5)	2-оос 5	15-аас 25
-5-аас (-10)	1-ээс 3	10-аас 15
-10-аас бага	1-ээс 1.5	5-аас 10

- 13.6. Анги танхим дахь агаарын бохирдол $\text{pm}_{2,5}$ нь 25-аас 50 мкг/м^3 , pm_{10} нь 50-аас 100 мкг/м^3 -ээс хэтрэхгүй.


- 13.7. Сургуулийн анги танхимын агаар сэлгэлтийн хоолой, төхөөрөмжид улирал тутам үзлэг, үйлчилгээ хийж хэвийн үйл ажиллагааг хангана.
- 13.8. Хортой бодис ашиглах, уур, дулаан, тоос ялгаруулах кабинет, лаборатори, номын сангийн уншлагын танхим, ариун цэврийн өрөө, биеийн тамирын заал, хувцас солих өрөө, усан сан (бассейн), хоол үйлдвэрлэлийн хэсэг нь агаар сорох, гаргах механик салхивч, зориулалтын тоног төхөөрөмжтэй байна.
- 13.9. Анги танхим бүрд агаарын хэм, харьцангуй чийгшилд хяналт тавих хэрэгсэл байршуулна.

14. АНГИ ТАНХИМ, ӨРӨӨ ТАСАЛГААНЫ ХАЯГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

- 14.1. Сургуулийн барилгын бүх дотор орон зай болон өрөөг зориулалтын дагуу хаяглаж, дугаарлаж, тэмдэглэнэ.



Зураг 7. Хичээлийн танхимын хаяг, дугаар (жишээ зураг)



Зураг 8. Өрөө тасалгааны хаяг, дугаарын самбар (жишээ зураг)

14.2. Өрөө тасалгааны тэмдгийн гадаргуугийн гэрлийг ойлгох чанар нь 70%-аас ихгүй байна.

14.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тэмдэг тэмдэглэгээ (Зураг 9).



Хадмал
тайлбартай



Сонсголын
бэрхшээлтэй иргэнд
зориулсан нэмэлт
цэстэй



Харааны бэрхшээлтэй



Орчны шуугиан
намсгагчтай



Тэргэнцэртэй
иргэн



Дохионы хэл



Брайл тэмдэг



Сонсголын
бэрхшээлтэй

Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тэмдэг

14.4. Биеийн тамирын заал, номын сан, цайны газар, компьютерын танхим гэх мэт хүн их цуглардаг газруудад хүчин чадлын тэмдэглэгээг хийнэ (Зураг 10).



Зураг 10. Танхимын хүчин чадлын тэмдэглэгээ

15. АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨ

15.1. Сургуулийн барилгын ариун цэврийн өрөөний хүчин чадлыг хүснэгт 3-т заасны дагуу төлөвлөнө.

Хүснэгт 3. Ариун цэврийн өрөөний норм

Д/д	Нэр	Норм
1	Суултуур	1 суултуур – 30 эмэгтэй 1 суултуур – 40 эрэгтэй
2	Хөтөвч /шээлтүүр/	1 хөтөвч – 40 эрэгтэй
3	Тосгуур	1 тосгуур – 40 эмэгтэй 1 тосгуур – 60 эрэгтэй
4	Цэвэр усны цорго	Хамгийн багадаа 3-ыг төлөвлөнө. 20 хүүхдэд 1 байхаар төлөвлөнө.

15.2. Ариун цэврийн өрөөнд дараах дагалдах хэрэгслийг байрлуулна. Үүнд:

- Саван савлагч;
- Толь;
- Ариун цэврийн цаас тогтоогч;
- Жорлонгийн суултуур;
- Бариул;
- Гар арчих цаасны сав;
- Хогийн сав.


15.3. Ариун цэврийн өрөө нь агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан байна.

15.4. Ариун цэврийн өрөөний цахилгааны холболт нь далд байна.


15.5. Суултуурууд өөр хоорондоо тусгаарлагчтай, усны татуурга нь хүүхэд ашиглахад хялбар, бүхээг нь чөлөөтэй суух орон зайтай, дотроосоо түгжих боломжтой байна.

15.6. Ариун цэврийн өрөөний кабины хаалга нь өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй байна.


15.7. Ариун цэврийн өрөөний кабин 0.9 м-ээс багагүй өргөн, 1.2 м-ээс багагүй урттай, 1.08 м²-аас багагүй талбайтай байна.



Зураг 11. Ариун цэврийн
өрөөний кабины хэмжээ
/Дотогшоо онгойлттой/




Зураг 12. Ариун цэврийн
өрөөний кабины хэмжээ
/Гадагшаа онгойлттой/



Зураг 13. Бие засах кабины нүүр тал


Зураг 14. Бие засах кабины хажуу тал

15.9. Эрэгтэй ариун цэврийн өрөөнд шалнаас А өндөрт хөтөвч (писсуар)-ийг байрлуулна.



Зураг 15. Сурагчдын насны ангилалд зориулсан хөтөвчний хэмжээ (писсуар) (жишээ зураг)


15.10. Эрэгтэй сурагчдын ариун цэврийн өрөөний нэг хөтөвч (писсуар)-ийг байршуулах ба түүний хоёр хажуу талд тулж барих бариулыг босоо чиглэлд тоноглоно.



Зураг 16. Тулгуур таяг ашигладаг ХБИргэнд зориулсан хөтөвч


Зураг 17. Тулгуур таяг ашигладаг ХБИргэнд зориулсан хөтөвч

15.11. Ариун цэврийн өрөө нь хүүхдийн биеийн онцлогт тохирсон, хүйсээр ялгасан таних тэмдэгтэй байна.



Зураг 18. Ариун цэврийн өрөөний таних тэмдэг

15.12. Ариун цэврийн өрөөний тосгуурын өндөр нь насны ангиллаас хамаарч зураг 19-д үзүүлсний дагуу, өргөн нь 0.6 м байна. Мөн суултуурын өндөр 0.45* м, урт нь 0.85* м байна /* - тухайн зураг төслөөс хамаарна/.




Зураг 19. Тосгуурын хэмжээ (жишээ зураг)

15.13. Ариун цэврийн өрөөний шал нь нэг түвшинд байх бөгөөд халтирдаггүй зориулалтын материалтай байна.


15.14. Явган суултууртай бол тусгаарлагч болон хаалганы дээд, доод ирмэг шал болон таазнаас 10 см-ээс ихгүй зайтай байрлах ба явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулна.

15.15. Бие засах газрын суултуурын татуурга, хаалга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байна.

- 15.16. Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байна.
- 15.17. Ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд зориулсан нэгээс доошгүй тасалгааг төлөвлөх ба түүний хамгийн бага урт, өргөний хэмжээ 1650 мм х 1800 мм байна.
- 15.18. Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцрээс суултуур дээр шилжиж суух боломжийг хангахын тулд ариун цэврийн өрөө (кабин)-нд байгаа суултуурын хажуу хэсэгт тэргэнцэр байршуулах чөлөөт орон зай (талбай) гаргана (Зураг 20, 21).




Зураг 20. ХБИргэнд зориулсан ариун цэврийн өрөө



Зураг 21. ХБИргэнд зориулсан ариун цэврийн өрөө

16. ХОНГИЛ (КОРИДОР)

- 16.1. Сургуулийн хонгилд байршуулсан самбар, толь болон бусад зүйлсийг суралцагч, багш, ажилтанд эрсдэл үүсгэхгүй материалаар хийж сайтар бэхлэх бөгөөд тэдгээрийн ирмэг, буланд хамгаалалт хийнэ.



Зураг 22. Сургуулийн хонгил /Коридор/ (жишээ зураг)

- 16.2. Сургуулийн хонгилыг олон нийтийн үйл ажиллагаа явуулах, сурагчид хичээлийн бус цагаар амрах, суух, тоглох зориулалтаар тохижуулах тохиолдолд зорчих хэсгийг хаах, гэрэлтүүлэг, агааржуулалтыг бууруулах, эрсдэл үүсгэхүйц тавилга хэрэгсэл байршуулахыг хориглоно.
- 16.3. Хонгил (коридор)-т гарц чиглэлийн тэмдэг байрлуулна (Зураг 23).



Зураг 23. Гарц тэмдэг

17. АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 17.1. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНбД 21-02- 01-д заасны дагуу давхар тус бүрд гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэлтэй байна.
- 17.2. Сургууль нь гал унтраагч системтэй байх ба MNS 5566:2020 “Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” стандартыг хангана.
- 17.3. Сургуульд болзошгүй, гэнэтийн аюулын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд харагдахаар газар байрлуулна.
- 17.4. Хүүхэд унаж бэртэхээс сэргийлж цонхны салхивчны онгойх өнцгийг хязгаарласан түгжээтэй, хэрэв цонхны тавцан шалнаас 1м-ийн өндөрт байрлах тохиолдолд хамгаалалтын хаалттай байна.
- 17.5. Давхар бүрийн коридор, хүүхэд хөгжлийн өрөө, гал тогоо бусад нийтийн хэсэгт хяналтын камер суурилуулж, хяналтын дэлгэцийг жижүүр багшийн өрөөнд байрлуулна.
- 17.6. Онцгой байдлын гарц болон нүүлгэн шилжүүлэх зам, тэмдэг, тэмдэглэгээ нь тод, харагдах орчныг бүрэн хангаж, саадгүй байхаар төлөвлөнө.
- 17.7. Сургуулийн барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

18. ШАЛГАХ ХУУДАС

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засал нь шаардлага хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 4)-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Барилгын дотор засалд хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгальд ээлтэй, гэрчилгээгээр баталгаажсан материал ашигласан эсэх	☐	☐
2	Барилгын дотор болон гадна заслын хувийн хэрэг хөтөлдөг эсэх	☐	☐
3	Шат нь халтирдаггүй материалтай эсвэл халтирахаас сэргийлсэн хамгаалалттай эсэх	☐	☐
4	Шат нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангасан эсэх	☐	☐
5	Хичээлийн анги танхимд орох хаалганы өргөн нь 0.9м-ээс багагүй эсэх	☐	☐
6	Хаалга нь шилэн оруулгатай бол, доргилтод тэсвэртэй хатжуулсан шилтэй эсэх	☐	☐
7	Цахилгааны холболт гэрлийн унтраалга, разетка нь далд монтажтай, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх	☐	☐
8	Ариун цэврийн өрөөнд хүүхдийн насны ангилалд зориулсан суултуур, хөтөвч, гар угаах тосгуурыг байрлуулсан эсэх	☐	☐
9	Сургуулийн анги танхимын агаар сэлгэлтийн хоолой, төхөөрөмжид улирал тутамд үзлэг үйлчилгээ хийдэг эсэх	☐	☐
10	Ариун цэврийн өрөөний шал нь нэг түвшинд эсэх	☐	☐
11	Сургуулийн хонгилд байршуулсан зүйлсийг суралцагч, багш, ажилтанд эрсдэл үүсгэхгүй материалаар хийж сайтар бэхэлсэн эсэх	☐	☐
12	Сургуулийн барилга нь галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй эсэх	☐	☐
12	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэлтэй эсэх	☐	☐
13	Сургуульд болзошгүй, гэнэтийн аюулын үед авах арга хэмжээний бүдүүвч зургийг гаргаж, нийтэд харагдахаар газар байрлуулсан эсэх	☐	☐

Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал;
- БНБД 21-02-02 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм;
- БНБД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл;
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм;
- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга;
- БНБД 23-02-08 “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг”;
- MNS 6056:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, үндсэн шаардлага;
- MNS 6423:2019 “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага”;
- Manual for Planning and Construction of School Buildings. 2006;
- “The Building Quality Standards Handbook” by Victorian School Building Authority. 2019;
- Alaska School Design & Construction Standards. 2022;
- “School Design Standards” APS Facilities Design and Construction. 2022.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар